



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

ШУУРХАЙ ШТАБЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын хурал 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 19:30 цагт гишүүдийн 86 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг нийслэлийн Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, хурандаа А.Дашням даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Улсын онцгой комиссын ажлын хэсгийн хурлаас өгсөн үүргийн хэрэгжүүлэх талаар хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад

1.1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөр Онцгой комиссын даргын өгсөн үүргийн хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдыг дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах ажлыг эрчимжүүлж, хамрагдалтын тайлан мэдээг өдөр бүр 17:00 цагт nokshuurhaishtab@gmail.com хаягаар ирүүлж ажиллах.

Хоёр. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,
Нийслэлийн Цагдаагийн удирдах газар,
Нийслэлийн Соёл, урлагийн газар,
Нийслэлийн Спортын хороо,
Дүүргийн Онцгой комиссын дарга нарт

2.1. Соёл, урлаг, спортын үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан хуулийн этгээдтэй байгуулсан хариуцлагын гэрээнд оролцогч, үзэгчийн нэмэлт тунгийн хамрагдалт, Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний 48 цагийн хариу, шинжилгээ авах цэг, арга хэмжээг зохион байгуулах талаар нийслэл, дүүргийн Онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудад 5-7 хоногийн өмнө мэдэгдэх талаар нарийвчлан тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих.

Гурав. Нийслэлийн Спортын хороонд

3.1. Спортын үйл ажиллагааг үе шаттайгаар нээх чиглэл баримтлан, мэргэжлийн лигийн тэмцээн уралдаанаас бусад тэмдэглэлт ой, нутгийн зөвлөл, оюутан сурагчдын зэрэг тэмцээн уралдааны арга хэмжээг үе шаттайгаар явуулах зарчмыг баримталж, гэрээ байгуулагч талуудад мэдэгдэн, хяналт тавьж ажиллах.

Дөрөв. Дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт

4.1. Дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг идэвхжүүлэхтэй холбогдуулан томоохон зах худалдааны төвд дархлаажуулалтын цэгийг байгуулах боломжийг судалж, судалгааг нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 08:00 цагт ирүүлэх;

4.2. Коронавирусын халдвар (КОВИД-19)-ын тархалт буурч байгаа тул батлагдсан тохиолдлын ойрын хавьтлыг илрүүлэх, талбарын тархвар судлаачдын ажлыг эрчимжүүлэн зохих дүрэм журмын дагуу ажиллуулах;

4.3. Батлагдсан болон ойрын хавьтлын гэрийн хяналт болох халдвар тархахаас сэргийлсэн арга хэмжээг эрчимжүүлж хороод, хэсгийн ахлагч нарын оролцоо, үүргийг сайжруулах;

4.4. Дархлаажуулалтын суурин болон явуулын цэгүүдэд ажиллах эмч, эмнэлгийн ажилчдыг амилуулах суурь тусламжийн сургалтад давтан хамруулж бүртгэлжүүлэн, шаардлагатай багаж, төхөөрөмж, хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч бэлэн байдлыг ханган ажиллах;

4.5. Дархлаажуулалтын цэгт ажиллаж байгаа бүрэлдэхүүний цайны цагт зохицуулалт хийж тасралтгүй ажиллах боломжийг бүрдүүлэх;

4.6. Дархлаажуулалтын суурин цэгийн ажлын цагийг 09:00-20:00 цаг хүртэл ажиллуулах;

4.7. Дархлаажуулалтын цэгүүдийн байршил, ажиллах цагийн хуваарийг нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлэх.

Тав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс, Дүүргийн Шуурхай штабын дарга нарт

5.1. Соёл урлаг, спортын арга хэмжээ 50 хүртэл хувийн дүүргэлттэй нээсэнтэй холбогдуулан хариуцлагын гэрээний хэрэгжилт болон зах худалдааны төвүүдэд дархлаажуулалтын нэмэлт тунгийн шинээр нээгдэх цэг, хамрагдалтын талаар Нийслэл, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх.

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Д.Оюунбатад даалгав.

ШУУРХАЙ ШТАБЫН
ДАРГА, ХУРАНДАА



А.ДАШНЯМ